



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2014 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/42

Булган

Ёс зүйн хороо байгуулах тухай

Монгол улсын төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.2 дах заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Ёс зүйн хороо”-г доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	П.Хишигдаваа/Хууль зүйн хэлтсийн дарга/
Нарийн бичгийн дарга	Ч.Баттуяа /Төрийн захиргаа, удирдлагын Хэлтсийн мэргэжилтэн/
Гишүүд	Т.Дорж /Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн/ И.Бадамханд /Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн/ Э.Нямдорж /Нийтлэг үйлчилгээний албаны дарга/

2. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын албан хаагчдын баримтлах ёс зүйн хэм хэмжээний дүрэм, байгууллагын стандартын хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг нягтлан шалгах, дүгнэлт гаргах үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулахыг ёс зүйн хороонд даалгасугай.

ДАРГА



Л.БАТБОЛД